

## “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ - СТАТИСТИК” сэдэвт үндэсний чуулган

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030 ба дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгын биелэлтийг хангах нь”

УИХ-ын гишүүн,  
УИХ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны дарга,  
Засгийн газрын гишүүн С.Чинзориг

2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

Эрхэм хүндэт УИХ-ын дарга аа,  
Эрхэм хүндэт, хатагтай, ноёд оо!  
Хүндэт зочид, төлөөлөгчид өө!

Та бүхний энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2015 оны 9 дүгээр сард зохион байгуулсан 71 дүгээр чуулганы үеэр дэлхийн 193 орны төрийн тэргүүн нар ирэх 15 жилийн хугацаанд дэлхий нийтийн баримтлах хөгжлийн тулгуур зорилго, зорилтуудыг тодорхойлсон “Тогтвортой хөгжил - 2030” хөтөлбөрийг баталж, улс орнууд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг амлалт авсан.

Монгол Улс дээрх томоохон цогц хөтөлбөртэй уялдуулан өөрийн улсын урт хугацааны “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030” хөгжлийн бодлогын баримт бичгийг Улсын Их Хурлаас 2016 онд батлан хэрэгжүүлж байна. Тус баримт бичиг нь эдийн засаг, нийгэм, байгаль орчин, засаглал гэсэн 4 бүлэг, 44 зорилт, 22 шалгуур үзүүлэлттэй.

Эдгээр хөтөлбөр, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын Их Хуралд Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо байгуулан ажиллаж байна. 2016 онд Ерөнхий сайдаар ахлуулсан, Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх яамдын сайд нарыг оролцуулсан “Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний хороо”-г байгуулсан. Мөн Үндэсний хорооны удирдлага дор Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, аргачлал, арга зүй, мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлох үүрэгтэй 9 ажлын хэсэг байгуулагдсан.

“Тогтвортой хөгжил - 2030” хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030” хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад Засгийн газар буюу бодлогын талаас нь Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар дээрх хөтөлбөр, баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх асуудлыг, статистикийн талаас нь Үндэсний статистикийн хороо шалгуур үзүүлэлтүүдийг тооцон гаргах ажлыг хариуцаж, зангидан ажиллаж байна. Үндэсний статистикийн хорооноос 2017 оны 10 дугаар сард Тогтвортой хөгжлийн зорилгын 244 шалгуур үзүүлэлтийг хамруулан мэдээллийн бэлэн байдалд үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнгээр Монгол Улсад хамааралгүй 11 үзүүлэлт, шууд тооцох боломжтой 134, үүнээс албан ёсны статистикийн мэдээллээс тооцон

гаргахад бэлэн 61, захиргааны статистикийн мэдээллээс тооцон гаргах 73 үзүүлэлт, мэдээллийн эх үүсвэр тодорхойгүй 99 үзүүлэлт байна.

Бидний нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол салбарын бодлогын баримт бичгүүдийг дээрх хөтөлбөр, хөгжлийн стратегийн баримт бичигтэй уялдуулж, Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний шалгуур үзүүлэлтийн хүрээг тодорхойлж, тооцох ажил юм. Улс орнууд “Тогтвортой хөгжил - 2030” хөтөлбөрийн хэрэгжилтийг 2017 оноос эхлэн дэлхийн болон үндэсний түвшинд тайлагнаж эхлэх учир яамд, агентлаг, төрийн захиргааны бусад байгууллага өөрсдийн хариуцсан чиглэлийн тоо мэдээллээ тооцон гаргаж, Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх, Үндэсний статистикийн хорооны нэгтгэсэн тоо мэдээллийг ашиглан Үндэсний хөгжлийн газар тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийн үндэсний тайланг бэлтгэн гаргаж байх шаардлага тулгарч байна.

Энэ хүрээнд Үндэсний статистикийн хороо болон Үндэсний хөгжлийн газар санал санаачилга гарган тодорхой ажлуудыг хэрэгжүүлж байгаа боловч Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн явцыг тайлагнах эхний жил дуусах дөхөж буй энэ үед дараах асуудалд анхаарч ажиллах хэрэгтэй байна. Тухайлбал, Тогтвортой хөгжлийн зорилгыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд энэ механизмыг иж бүрэн ажиллуулах, энэ чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаануудыг уялдуулан зохицуулах үүднээс Ерөнхий сайдаар ахлуулсан “Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний хороо”, 9 ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах шаардлагатай байна. Мөн яам, агентлаг, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой болгож, дээр дурдсан ажлуудыг эрчимжүүлэх нь чухал байна. Бодлогын уялдааг хангах, тоо мэдээлэл харилцан солилцох, хэрэгжилтийн тайлан боловсруулан гаргахад их дээд сургууль, судалгааны институт, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах зүйтэй юм.

Өнөөдрийн үндэсний чуулган бидэнд Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгарч буй сорилт бэрхшээлээ хэлэлцэх, шийдвэрлэх боломж, арга замын талаар санал бодлоо солилцох, цаашдын хамтын ажиллагаагаа сайжруулах, бэхжүүлэх боломжийг олгоно гэдэгт итгэл дүүрэн байна.

Үндэсний чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье!

---oOo---